**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.11.13

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Биелэлт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| | | **Нэг : Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд** | | |
| 1.1 | Хэлтсийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах | Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс тус хэлтэст холбогдолтой 4 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж ерөнхий газарт хүргүүлээд байна. | 100% |
| 1.2 | Хэлтсиийн албан хаагчдад хүн худалдаалахтай холбоотой гарсан хууль тогтоомж журмын талаар мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах | Хэлтсийн албан хаагчдад 2-оос доошгүй сургалт сурталчилгааг зохион байгуулах | "Хүн худалдаалахтай холбоотой гарсан хууль тогтоомж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр Хяналтын улсын байцаагч Т.Цэвэлмаа албан хаагчдад 2024 оны 11 сарын 13-ны өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтад 13 албан хаагч хамрагдаж мэдээлэл авсан.   | 70% |
| | | **Хоёр: Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах хүрээнд** | | |
| 2.1 | Цахим орчинд үйлдэгдэж буй хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий сэрэмжлүүлэг бэлтгэн албан хаагчдад хүргэх, Хэлтсийн мэдээллийн самбарт, цахим хуудаст хүн худалдаалах | Хэлтсийн мэдээллийн самбарыг 2-оос доошгүй удаа шинэлсэн байх | Хэлтсийн албан хаагчид "Хүн хулгайлах" "Бэлгийн мөлжлөгөөс" "Сэргийлье" "Хамгаалъя" "Мөрөөдлийн шухэр" аянд нэгдэв. Хэлтсийн цахим хуудсанд Хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар мэдээлэл зөвлөгөө авах утас 1800-1903 талаар мэдээлэл байршуулаад байна. Мөн мэдээллийн нээлттэй ил тод самбарт Цахим орчинд үйлдэгдэж буй хүн худалдаалах, | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий зурагт хуудас, богино хэмжээний шторк, сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулах | | бэлгийн мөлжлэгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий зурагт хуудас мэдээллийг байршуулсан.<br><br>Эд хөрөнгийн эрхийн бүртгэгч З.Чагцалмаа ivoice.mn сайтад нийтлэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлд орох гэж буйгаа хэрхэн мэдэх вэ? талаар албан хаагчдад мэдээллэж ажилласан. | |
| **Гурав: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх** | | | | |
| 3.1 | Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлтсийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалт зохион байгуулж хэлтсийн албан хаагчдын 70-аас дээш хувийг хамруулсан байх | Хэлтсийн дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч З.Чагцалмаа "Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлэгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр 2024 оны 10 дугаар сарын 24-ны сургалт зохион байгуулсан. Сургалтад 12 албан хаагч хамрагдав.<br> | 100% |
| **Дундаж үнэлгээ** | | | | **92.5%** |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН :

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭГЧ З.ЧАГЦАЛМАА

ХЯНАСАН :

ДАРГА З.БАЯНДУГАР

4611...

ГСТ7450 3223010003